

2 дахь жилийн заах аргын хөтөлбөрийг хэвлэх тухай —

Токиогийн Гакүгэй Их Сургууль

Шинохара Фүмихико

(Япон гэл /Japanese)

“Бага ангийн сурагчдын бие даан суралцах чадварыг бий болгож, тэдний хөгжлийг дэмжих заах аргыг боловсруулах ба сайжруулах”-д тус болно гэдэгт итгэж энэхүү хөтөлбөрийг энд хүргээл болгож байгаадаа зохиогчийн хувьд маш их баяртай байна.

Хөтөлбөрийг бичих болон хэвлэхэд тусалсан багш нартаа чин сэтгэлээсээ талархаж байгаагаа илэрхийлэхийн хамт төслийн үйл ажиллагааны гүйцэтгэлд оролцож буй монгол улсын боловсрол соёл шинжлэх ухааны яам болон бусад холбогдох байгууллагууд, туршилт сургуулиуд, аймгийн боловсрол соёлын газрууд, орон нутагт оршин сууж буй айл өрхүүдэд гүн туслалцаа үзүүлж байгаа тань маш их баярлаж байгаагаа илэрхийлмээр байна.

Энэхүү хөтөлбөр маань 2007 оны эхний жилийн хэвлэл болох IT боловсролын хөтөлбөрөөс ялгаатай бөгөөд зөвхөн Улаанбаатар хотод явагдсан туршилт хичээлүүд дээр үндэслэсэн биш ялангуяа уг төслийн 2 дахь жилээсээ загвар аймаг болох Сэлэнгэ, Дорнод аймаг дахь онцлог бүхий IT боловсролд хамаарах туршилт хичээлийн үр дүнг тусгаж бичсэн. Өөрөөр хэлбэл төв ба орон нутгийн сайн тал ба байгаа онцлог мөн сургуулийн бодит байдал болон бага насны хүүхэд сурагчдын хөгжлийн үе шатны онцлог гэсэн 2 талыг авч үзсэн IT боловсролын онол ба хэрэгжилттэй холбоотой 2 дахь жилийн үр дүн юм. Мөн төсөл эхлэхдээ анхаарч буй чухал зүйлсийн нэг болох бусад хичээлүүд дэх IT-гийн тогтолцоог оруулж, тус тусад нь ижил төстэй нийтлэг хөтөлбөрийн ухагдахуун, арга зүйн тодорхойлолтыг ч сайтар мэдэрч нэгтгэсэн.

Нөгөө талаар энэ хөтөлбөр маань аливаа кёозай кэнкюүд нэлээд анхаарлаа хандуулсан гэдгийг нь харах боломжтой.

Кёозай кэнкюү гэдэг нь “Зорилгоо үр дүнтэйгээр биелүүлэхийн тулд, багшийн заах аргын чадвар, сурагчийн суралцах үйл ажиллагаанд туслахын тулд зохиогдож, сонгогдон гарч ирдэг сурах бичгийн судалгаа” юм. Энгийн үгээр хэлбэл Кёозай кэнкюү гэдэг нь заах болон сурах зорилгын үр дүнтэй биелэлт ба бага насны хүүхэд бага ангийн сурагчдыг тус бүрийн суралцах явцыг хамгийн тохиромжтой болгож хичээл заах ба суралцахуйг бий болгохын тулд хичээлийн бодлого, хичээлийн загвар, медиа, материалыг өөрсдийн эргэн тойрноосоо

эрж хайж, хэрвээ эдгээр нь байхгүй бол өөрөө хийж, судалж үзэх, энэ бүгдийг хөтөлбөртөө бүхлээр нь авч оруулж, нэгтгэх нь багш нар хоорондын хамтын ажиллагаа юм. Улмаар, Кёозай кэнкюүгийн эцсийн зорилго бол сурах бичиг хийх, хичээл заах бөгөөд хүүхэд нэг бүрийн хөгжил ба хичээлийн шинжлэх ухаанч хөгжлийг харж үзэж хичээлийнхээ зорилгод хамгийн тохирсон хөтөлбөрийн агуулгыг хийхэд оршдог. Өөрөөр хэлбэл сурах бичгийн судалгааны зорилго бол сурах бичиг хийх, хичээл явуулах зэрэгт орших бөгөөд зорилгын бүтэц, зорилгын нарийвчлалт, агуулгын сонголт, материал ба медиагийн сонголт ба хөгжил, үнэлгээ юм.

“Хувь хүний үүсэл нь системийн үүслийг давтдаг”. Өөрөөр хэлбэл, хүн нэг бүрийн хөгжил нь хүн төрөлхтөний хөгжлийн товчилсон зураг юм.

Хөгжлийн үе шатанд тохирсон хөтөлбөр ба сурах гэсэн өнцгөөс суралцагчийн хариултыг шууд “Буруу” гэж дүгнэхээс татгалзах хэрэгтэй. Жишээлбэл, J. Пиажэ нь, ихэнх анхан шатны боловсролын үе шатанд “хүнд ба хурд”-аар ангилаагүй байсан ч энэ нь алдаа биш. Харин дунд шатны боловсролоос хойш, ялангуяа ахлах сургуулийн түвшинд бол “Хүнд” ба “Хурд”-ны ялгааг тайлбарлаж чадахгүй бол алдаа болно. Гэвч энэ нь, тэгж урьдчилж бэлдсэн ерөнхий бэлтгэлтэй байлаа ч, хүүхдийг урдаа барьсан дадлага дээр газар нутаг болон хүүхдийн бодит байдалд мэдрэмжтэйгээр харилцаж, өөрчлөхөөс өөр аргагүй заах арга байвал гэсэн байдаг.

Үнэхээр, хүн нэг бүрийн хөгжил нь Аристотелийн үзэл бодлоос Галлейн үзэл бодол хүртлэх хөгжил дэвшил, өөрөөр хэлбэл орчин үеийн шинжлэх ухаан руу шилжсэн өөрчлөлт юм.

IT боловсролоор хэлбэл, жишээлбэл “Мэдээ”, “Мэдээлэл”, “Мэдлэг” гэж ангилаагүй байсан ч анхан шатны боловсролд бол алдаа биш. Анхан шатны боловсролын дунд үеэс хойш дунд шатны боловсролын үе шатанд сурах агуулга нь дээшлэхтэй уялдаад, өдөр тутмын ухагдахуунаас шинжлэх ухаанч ойлголт руу шилжсэн гүнзгийрэлт ба ангилал бий болж, мэдээ нь амьд жинхэнэ хэрэглээ болж шинжлэх ухааны мэдлэг болон хуримтлагдахын зэрэгцээ, өдөр тутмын хэрэглээний үг шинжлэх ухааны үг болж хөгжих хөтөлбөр байх шаардлагатай. Ийм зааварчилгааны дараа ч ойлголт ба үгийн шинжлэх ухаанч байдал байхгүй бол энэ нь алдаа болох бөгөөд алдааныхаа шалтгааныг олж засах, цаашдын заах аргаа сайжруулахад хүч хөдөлмөрөө гаргахыг багшаас шаардаж байна.

Япон улсын Боловсрол Шинжлэх Ухааны Яам нь 2008 оны 3 сарын 28-ны өдөр шинээр цэцэрлэгийн боловсролын зааварчилгаа, бага болон дунд сургуулийн хичээлийн хөтөлбөрийн зааварчилгаа зэргийг гаргасан. 1947 онд туршилтаар 1951 оны нэгдүгээр

тогтоолоос хойш бараг 10 жил тутамд шинэчилж байдаг бөгөөд энэ нь 7 дахь удаагийн тогтоол юм.

Шинэ гарсан бага дунд сургуулийн хичээлийн зааварчилгаанд тус бүр “Ерөнхий 1-р зүйл” дотор өмнөх 1998 оны хичээлийн хөтөлбөрийн зааварчилгаанд нэг л удаа гарсан “Хөгжлийн үе шаг” гэсэн үг, 3 газар нэмэгдэж орсон нь анхаарал татаж байна. Эхлэлд нь “Сургуулийн боловсролын үйл ажиллагааг хөгжүүлэхтэй холбогдуулаад” гэж эхэлдэг мөрөнд, нөгөө хоёр нь “Сургууль дахь ёс суртахууны боловсрол нь”, “Сургууль дахь биеийн тамир, эрүүл мэндтэй холбоотой заавар” гэсэн мөрөнд бий.

Бага насны сурагчдын хөгжлийн үе шатанд тохирсон боловсролыг эсвэл, тогтворгүй баталгаагүй үе учраас л япон улсын боловсролын хувьд ч илүү онцолж байгаа байдлыг лавлаж болно.

Энэ төслийн тэргүүн зорилго бол “Хүүхдийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн арга”-ыг загвар аймагт дэлгэрүүлэх бөгөөд “Хүүхдийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн арга”-ыг Монгол улс даяар түгээх явдал юм. Одоо л хийх үе нь билээ.

Энэ хөтөлбөрийг монгол дахь зөвхөн төсөлд оролцогч загвар сургуулиуд дээр ч биш бусад олон сургуулиудад хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүний үр дүнгээ ойрхон байгаа хариуцагч эсвэл хөтөлбөрт бичигдсэн зохиогчид мэдээлэл зэргээр дамжуулан шинжлэх ухааны шийдэл ба боловсруулалтыг даван нийтэд зарлагдсанаар, хөтөлбөр улам бүр төгөлдөржиж, монгол болон япон улсын боловсролын хөгжилд илүү тус болох нь гарцаагүй.

Энэхүү хөтөлбөр нь зөвхөн IT ийн боловсролтой холбоотой хариуцагч төдийгүй, IT –г хэрэглэж, шавь төвтэй төгс баталгаатай боловсролын хөгжлийг хүсч буй бүх багш сурган хүмүүжүүлэгчдэд хүрнэ гэдэгт найдаж байна.

(Орчуулсан: Токио Гакугей Их Сургуулийн магистрантур Жамьянгийн Дулмаа)